



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**Шүүхийн тогтолцооны агуулга,
хэлбэрийн талаарх гадаадын зарим
улсын харьцуулсан судалгаа**



ЛАВЛАГАА

**Шүүхийн ерөнхий
зөвлөлийн гишүүн
Д.Эрдэнэчулууны
захиалгаар бэлтгэв.**

Улаанбаатар хот

2015 оны 12 дугаар сар



ГАРЧИГ

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:.....	2
2. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО.....	2
2.1. ОХУ-ын Шүүхийн тогтолцоо	2
2.2. БНХАУ-ын шүүхийн тогтолцоо	4
2.3. Молдав улсын шүүхийн тогтолцоо.....	6
2.5. Узбекистан улсын шүүхийн тогтолцоо.....	10
2.6. Турк улсын шүүхийн тогтолцоо	11
2.7. Эстони улсын шүүхийн тогтолцоо.....	13
2.8. Казахстан улсын шүүхийн тогтолцоо.....	14
3. ДҮГНЭЛТ	15





ШҮҮХИЙН ТОГТОЛЦООНЫ АГУУЛГА, ХЭЛБЭРИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА¹


1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Тус лавлагаагаар ОХУ, БНХАУ, Молдав, Беларусь, Узбекистан, Турк, Эстони, Казахстан улсын шүүхийн тогтолцооны талаарх мэдээллийг харьцуулан бэлтгэлээ. Харьцуулсан судалгаа хийх улсуудыг сонгохдоо эрх зүйн бүл болон эрх зүйн хөгжлийг харгалзав. Ингэхдээ тухайн улсын Үндсэн хуулиас шүүх эрх мэдлийн талаарх зохицуулалтыг түүвэрлэж, түүнийг бусад эх сурвалжаар тодруулсан болно.

Түлхүүр үг: Шүүхийн тогтолцоо; хэрэг, маргааны төрөл

2. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

2.1. ОХУ-ын Шүүхийн тогтолцоо



ОХУ-ын Үндсэн хуулийн 118 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар шүүх эрх мэдлийн байгууллага нь Үндсэн хуулийн болон эрүү, иргэний, захиргааны хэргийн шүүн таслах үйл ажиллагаа явуулна. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар ОХУ-ын шүүхийн тогтолцоог ОХУ-ын Үндсэн хууль болон холбооны үндсэн хуулиар байгуулна. Харин онцгой шүүх байгуулахыг зөвшөөрөөгүй.²

Үндсэн хуулиас гадна ОХУ-ын Шүүхийн тогтолцооны тухай 1996.12.31-ний өдрийн Холбооны үндсэн хуулиар шүүхийн тогтолцоог зохицуулж байна.³

ОХУ-д дараах шүүх байна.⁴ Үүнд:

- Үндсэн хуулийн шүүх. Ерөнхийлөгчийн санал болгосноор Холбооны зөвлөлөөс томилогдох 19 шүүгчээс бүрдэх Үндсэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих шүүх;
- Дээд шүүх. 123 шүүгчээс бүрдэх ерөнхий харьяаллын буюу эрүү, иргэн, захиргааны хэргийн асуудлаарх хяналтын шатны шүүх. Энэ шүүх нь бүгд

¹ Тус лавлагааг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Мандах (LL.D), Судлаач Л.Галбаатар, Шүүхийн судалгаа, сургалт хариуцсан референт М.Сэлэнгэ нар гүйцэтгэсэн болно.

² https://www.constituteproject.org/constitution/Russia_2014?lang=en

³ Overview of the Judicial System of the Russian Federation

<http://www.supcourt.ru/catalog.php?c1=English&c2=The%20Judicial%20System%20of%20the%20Russian%20Federation>

⁴ Courts and Case Russia <http://www.lexadin.nl/wlg/courts/nofr/oeur/lxctrus.htm>



найрамдах улсууд болон автономит бүс нутгуудын дээд шүүхийг оролцуулаад доод шатны шүүхүүдийн хувьд давж заалдах шатны шүүх болно;

- Арбитрын дээд шүүх. Энэ шүүх нь Оросын төрийн байгууллага болон худалдааны талуудын хооронд гарсан худалдаатай холбоотой маргааныг ерөнхийлөн харьяална. Маргааны тал нь бизнесийн үйл ажиллагаатай холбоогүй иргэн байх юм бол ийм маргааныг ердийн харьяаллын шүүхээр шийдвэрлэнэ.⁵
- Холбооны давж заалдах шатны шүүх. Үүнд Холбооны Арбитрын шүүх (Баруун Сибирийн бүс нутгийн Холбооны арбитрын шүүх, Зүүн бүсийн Холбооны арбитрын шүүх, Москвагийн бүсийн Холбооны арбитрын шүүх, Баруун хойд бүсийн Холбооны арбитрын шүүх, Поволжскийн бүсийн Холбооны арбитрын шүүх, Волга-Вятскийн бүсийн Холбооны арбитрын шүүх, Зүүн Сибирийн бүсийн Холбооны арбитрын шүүх, Хойд Кавказын бүсийн Холбооны арбитрын шүүх, Уралын бүс нутгийн Холбооны арбитрын шүүх); Арбитрын давж заалдах шатны шүүх (Төвийн бүсийн Арбитрын давж заалдах шатны шүүх, 1-20-р тойргийн Арбитрын давж заалдах шатны шүүх) багтана;
- Давж заалдах шатны шүүх. Нийт 91 шүүх бий. Ерөнхий харьяаллын бүс нутгийн шүүх бөгөөд орон нутгийн тойргийн шүүхийн хувьд давж заалдах шатны шүүх болно. Онц ноцтой гэмт хэргээс бусад гэмт хэргийн хувьд түүний шууд үндсэн харьяалалд байна;
- Бүс нутгийн арбитрын шүүх. Нийт 78 шүүх бий.
- Анхан шатны шүүх. Анхан шатны 2500 шүүх байх бөгөөд нийт эрүү, иргэний хэргийн 90%-ийг хянан шийдвэрлэдэг;⁶
- Ардын шүүх;
- Бусад шүүх (Москвагийн тойргийн цэргийн шүүх).

Арбитрын шүүхээс өөр дотоодын харилцааны тусгай харьяаллын шүүх Орос улсад байхгүй.⁷ Арбитрын шүүхийн тогтолцооны хүрээнд оюуны өмчийн эрхийн төрөлжсөн шүүх байдаг.⁸

⁵ Legal System of Russia <http://pages.uoregon.edu/jbonine/jud-syst.html>


⁶ Basic Facts About Russia - Political and Legal Systems
http://www.priorgroup.com/index.php?option=com_content&view=article&id=82&Itemid=38&lang=en&limitstart=6

⁷ The Judicial system of Russia <http://pages.uoregon.edu/jbonine/jud-syst.html>

⁸ Overview of the Judicial System of the Russian Federation
<http://www.supcourt.ru/catalog.php?c1=English&c2=The%20Judicial%20System%20of%20the%20Russian%20Federation>



2.2. БНХАУ-ын шүүхийн тогтолцоо



БНХАУ-ын шүүхийн тогтолцоог БНХАУ-ын Үндсэн хуулийн 123-128 дугаар зүйл болон БНХАУ-ын Ардын шүүхийн зохион байгуулалтын тухай 1979 оны хуулиар зохицуулдаг. Ардын шүүхийн зорилт нь эрүүгийн болон иргэний хэргийг хянан шийдвэрлэх, гэмт этгээдийг шүүхийн журмаар ял шийтгэх, пролетарын /ажилчин ангийн/ диктатурын системийг /дарангуйлалын тогтолцоо/ хамгаалах зорилгоор иргэний маргааныг шийдвэрлэхэд оршино гэж заасан.

БНХАУ-ын Үндсэн хуулийн дагуу Ардын шүүх нь төрийн шүүн таслах байгууллага бөгөөд дотроо Бүх Улсын Ардын Дээд Шүүх, орон нутаг дахь бүх шатны шүүхүүд, төмөр замын, цэргийн гэх мэт тусгай мэргэжлийн шүүхүүдэд хуваагдана.⁹

Бүх улсын Ардын дээд шүүх нь шүүхийн дээд байгууллагын хувьд орон нутгийн болон тусгай шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавьж харьяа бүх шүүхийн байгууллагын тайлан дүн мэдээг Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал болон түүний Байнгын хороонд тайлагнадаг.

БНХАУ-ын засаг захиргааны нэгж ба шүүхийн зохион байгуулалт¹⁰

БНХАУ-ын Үндсэн хуулийн дагуу Бүх Хятадыг муж, өөртөө засах орон, шууд харьяа хот, онцгой засаг захиргааны нэгж гэж 4 хуваадаг. БНХАУ нь өдгөө нийт 22 муж (Тайванийг оруулбал 23), 5 өөртөө засах орон, 4 шууд харьяа хот, 2 онцгой засаг захиргааны орон (Хонг Конг, Макао) гэж зүйчлэгдэх нэр бүхий 33 засаг захиргааны нэгж (Тайваньтай 34) байна.¹¹

БНХАУ-ын Ардын шүүхийн хувьд БНХАУ-д Бүх улсын хэмжээнд нэг Ардын дээд шүүх байдаг бол муж, өөртөө засах орон, шууд харьяа хот нь засаг захиргааны нэгжийн дагуу анхан шатны, дунд шатны, дээд шатны Ардын шүүхтэй болно. Өөрөөр хэлбэл БНХАУ-ын 22 муж, 5 өөртөө засах орон, 4 шууд харьяа хотод тус бүр нэг Ардын Дээд шүүх байдаг. Тухайлбал, БНХАУ-ын засаг захиргааны нэгж болох өөртөө засах орон нь тал мужийн дайтай өөртөө засах тойрог, аймгийн энтэй хот, өөртөө засах тойрог, аймаг зэрэгт хуваагдаж тус бүрт нь засаг захиргааны нэгжийн дагуу дунд шатны шүүх байдаг бол эдгээр засаг захиргааны нэгж нь дүүрэг, хошуу, сянь зэрэгт

⁹ <http://www.china.com.cn/ch-sifa/sifa-2/sifa2-1.htm>

¹⁰ http://www.gov.cn/test/2005-06/15/content_18253.htm

¹¹ Тайван, Хонг Конг, Макао нь БНХАУ-ын эх газарт хамаардаггүй тул тус лавлагаанд зөвхөн эх газрын засаг захиргааны нэгжийг авч үзэв.



хуваагддаг бөгөөд мөн тус бүрт нь анхан шатны шүүхүүд засаг захиргааны нэгжийн дагуу байрладаг байна.

Анхан шатны ардын шүүх нь шүүхийн дарга буюу Ерөнхий шүүгч 1, дэд дарга буюу дэд Ерөнхий шүүгч болон бусад шүүгчдээс бүрдэнэ. Анхан шатны ардын шүүх нь Эрүүгийн хэргийн шүүн таслах танхим, иргэний хэргийн шүүн таслах танхим болон эдийн засгийн хэргийн шүүн таслах танхимтай байх бөгөөд тус бүр танхимын тэргүүн, дэд тэргүүнтэй байна. Анхан шатны шүүх нь тухайн орон нутаг, хүн ам, хэргийн тоо зэргийг үндэслэн Ардын шүүхийн танхимыг байгуулж болдог байна.¹²

БНХАУ-ын Анхан шатны ардын шүүх нь хуульд заасны дагуу хэргүүдийг харьяалан анхан шатны журмаар хэргийг шийддэг анхан шатны шүүх юм. БНХАУ-ын дунд шатны шүүх нь хуульд заасны дагуу давж заалдах шатны журмаар Анхан шатны ардын шүүхийн хэргийг хянан шалгах аас гадна хуульд заасан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг байна. Тухайлбал цаазаар авах ял, онц хүнд гэмт хэрэг, гадаад улсын иргэн холбогдсон гэмт хэрэг, үнийн дүн нь их хэмжээний иргэний маргаан зэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг байна. Дээд шатны ардын шүүх нь мөн хуульд заасны дагуу давж заалдах шатны журмаар Дунд шатны ардын шүүхийн хэргийг хянан шалгадаг бөгөөд хуульд заасан тухайн муж, өөртөө засах орон, шууд харьяа хотын онц ноцтой гэмт хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг байна. БНХАУ-ын Бүх улсын ардын дээд шүүх нь хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж болох хэдий ч энэ нь маш ховор бөгөөд БНХАУ 1949 онд байгуулагдсанаас хойш 2 л удаа анхан шатны журмаар хэргийг эцэслэн шийдвэрлэж байсан байна.¹³

БНХАУ-д хэргийг зөвхөн 2 шатны шүүхээр хянан шийдвэрлэдэг ба давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн шийдвэр нь эцсийн шийдвэр болдог байна. Зөвхөн цаазын ял ногдуулсан шүүхийн аль ч шатны шийдвэрийг БНХАУ-ын Бүх улсын ардын дээд шүүх хянан шалгадаг байна.¹⁴

БНХАУ-ын Ардын шүүхийн бүтэц, зохион байгуулалт

БНХАУ-ын Ардын шүүх нь 4 шатны шүүхээс бүрдэх ба анхан шатны шүүх, дунд шатны шүүх, дээд шатны шүүх болон Бүх улсын Ардын Дээд шүүхээс бүрдэх бөгөөд цэргийн хэргийн шүүх, төмөр замын хэргийн шүүх, усан тээврийн шүүх зэрэг дагнасан Ардын шүүхээс бүрдэнэ.¹⁵

БНХАУ нь тодорхой салбарын дагнасан эсхүл тодорхой газар нутагт тусгайлан заасан хэргийг хянан шийдвэрлэх шүүхийг байгуулдаг. Энэ нь засаг захиргааны нэгжийн дагуу байгуулагддаггүй бөгөөд ердийн эрүүгийн хэргийг шийддэггүй байна. БНХАУ-ын Шүүхийн зохион байгуулалтын тухай хуульд Цэргийн хэргийн шүүх байгуулахыг тодорхой заасан бөгөөд бусад Дагнасан Ардын шүүхийг тухайлан заагаагүй бөгөөд тухайн бодит шаардлагад үндэслэн байгуулна гэж заасан байна.¹⁶

¹²

<https://zh.wikipedia.org/wiki/%E5%9F%BA%E5%B1%82%E4%BA%BA%E6%B0%91%E6%B3%95%E9%99%A2>

¹³ http://www.npc.gov.cn/npc/sjb/2013-02/19/content_1755111.htm

¹⁴ <http://baike.baidu.com/view/635928.htm>

¹⁵ http://news.xinhuanet.com/ziliao/2003-08/13/content_1024723.htm

¹⁶ http://www.npc.gov.cn/wxzl/gongbao/2006-12/05/content_5354938.htm



Дагнасан Ардын шүүх¹⁷

Дагнасан Ардын шүүх нь орон нутгийн ардын шүүхээс дараах байдлаар ялгаатай болно.

- (1) Дагнасан ардын шүүх нь тусгай зохион байгуулалттайгаар эсхүл тусгай хүрээний хэргийг шүүн таслах эрх бүхий байгууллага юм. Орон нутгийн ардын шүүх нь засаг захиргааны нэгжийн дагуу байгуулагдсан шүүн таслах байгууллага юм.
- (2) Дагнасан Ардын шүүхийн хэргийн харьяалал нь тусгай шинжийг агуулна. Өөрөөр хэлбэл, дагнасан Ардын шүүхийн хянан шийдвэрлэдэг хэргийн шинж нь Орон нутгийн Ардын шүүхээс ялгаатай бөгөөд харьяалан шийдвэрлэж байгаа хэргийн төрөл нь тодорхой хязгаартай болно.
- (3) Дагнасан Ардын шүүхийг байгуулах болон түүний ажилтан, алба хаагчийг томилох зэрэг асуудал нь Орон нутгийн Ардын шүүхээс ялгаатай болно. Тухайлбал Цэргийн хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч буюу дарга нь Ардын Их хурлаас сонгогдсон биш Бүх улсын Ардын Дээд шүүх Бүх цэргийн дээд зөвлөлтэй хамтран томилдог байна.

Одоогийн байдлаар БНХАУ-д Цэргийн хэргийн шүүх, Далайн хэргийн шүүх, Төмөр замын тээвэрлэлтийн шүүх, Ойн модны шүүх, Хөдөө аж ахуйн тариалалтын шүүх, Газрын тосны шүүх зэрэг Дагнасан Ардын шүүхүүд байна.

2.3. Молдав улсын шүүхийн тогтолцоо



Молдав Улсын шүүхийн үндсэн тогтолцоо нь дараах шүүхээс бүрдэнэ.¹⁸

- Үндсэн хуулийн шүүх,
- Дээд Шүүх,
- Давж заалдах шатны шүүх,
- Трибунал /анхан шатны шүүх/
- Төрөлжсөн шүүх /цэргийн, нягтлан бодох бүртгэлийн, эдийн засгийн шүүх/ зэргээс бүрдэнэ.

Үндсэн хуулийн шүүх

Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлнэ. Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих цорын ганц байгууллага юм. Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн дээд хүчин чадлыг баталгаажуулах, эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарилах зарчмын биелэлтийг хангах,

¹⁷ <http://baike.baidu.com/view/933543.htm>

¹⁸ Молдав Улсын Үндсэн хуулийн 115 дугаар зүйл



иргэний өмнө төрийн хүлээх, төрийн өмнө иргэний хүлээх хариуцлагыг баталгаажуулах үүрэгтэй байна.¹⁹ Үндсэн хуулийн шүүх нь асуулгын дагуу парламентаас баталсан хууль, парламент, тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр, түүнчлэн нэг тал нь Молдав улс байгаа олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцсэн эсэхэд хяналт тавина. Үүнээс гадна Үндсэн хуулийг тайлбарлах; түүнийг өөрчлөх талаарх саналд хариу өгөх; парламент, Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгын үр дүнг баталгаажуулах; парламентыг тараах болон Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь түр огцруулах, эсхүл чиг үүргийг нь түр гүйцэтгүүлэх нөхцөл байдлыг тогтоох; Шүүхийн дээд танхимаас хандсан эрх зүйн актыг Үндсэн хуульд нийцээгүйд тооцуулах асуудлыг шийдвэрлэх; улс төрийн намын үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Үндсэн хуулийн шүүх нь холбогдох шийдвэр гаргасан үеэс хууль болон эрх зүйн бусад акт, эсхүл тэдгээрийн зарим хэсэг нь хүчингүй болно. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд давж заалдахгүй.

Давж заалдах шатны шүүх

Орон нутаг болон дүүргүүдэд байрлаж шүүхийн бусад шатанд харьяалуулснаас бусад бүх хэргийг хянан шийдвэрлэнэ. Давж заалдах танхимын тойрогт бүх трибунал, төрөлжсөн шүүх орно. Төрөлжсөн шүүхүүд нь шүүхийн тогтолцооны үндсэн хэсэг байна. Тэдгээр нь трибуналын адил статустай байна.

Трибунал /анхан шатны шүүх/

Трибунал /анхан шатны шүүх/ нь хэд хэдэн шүүхийг багтаасан тодорхой тойрогт үйл ажиллагаа явуулна.²⁰ Бүгд Найрамдах Молдов улсын Үндсэн хуулийн 115 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар онцгой шүүх байгуулахыг хориглоно.

Ердийн шүүх нь хуульд зааснаар бусад шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаанаас бусад бүх төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэнэ.

Төрөлжсөн шүүх

Цэргийн шүүх нь төрөлжсөн шүүхийн нэг хэсэгт тооцогддог бөгөөд зэвсэгт хүчний үйл ажиллагаанд шүүхийн хяналтыг хэрэгжүүлдэг.²¹

Мөн эдийн засгийн шүүх нь хувь хүн, хуулийн этгээдийн хооронд эдийн засгийн харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэх төрөлжсөн шүүх юм. Тус шүүх нь эдийн засгийн салбарын хууль тогтоомжийг нэг мөр, зөв хэрэглэх замаар эдийн засгийн үйл ажиллагааны хууль ёсны баталгааг бүрдүүлдэг.

Нягтлан бодох бүртгэлийн шүүх²²

Бүгд Найрамдах Молдов улсын Үндсэн хуулийн 115 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүх эрх мэдлийг анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, Дээд шүүх хэрэгжүүлнэ. Тус зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар тодорхой хэрэг, маргааны төрлөөр төрөлжсөн шүүх нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулна. Энэ нь төрөлжсөн шүүх нь

¹⁹ Молдав улсын Үндсэн хуулийн 134 дүгээр зүйл

²⁰ Шүүхийн байгуулалтын тухай хууль

²¹ Performing Legal Research: the Moldovan Experience. By Mariana Harjevschi and Svetlana Andritchii
http://www.nyulawglobal.org/globalex/Moldova.html#_Ordinary_courts

²² <http://www.ccrm.md/pageview.php?l=en&idc=175&t=/About-Us/Mission-and-Role>



шүүхийн тогтолцооны нэг хэсэг бөгөөд Дээд шүүхийн хяналтаас гадуур байж болохгүйг харуулж байна.²³


Нягтлан бодох бүртгэлийн шүүхийн тухай шинэ хууль 2009 оны 1-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон. Энэ хуулийн дагуу тус шүүх нь санхүүгийн үйл ажиллагаанд шүүхийн хяналт тавих чиг үүрэг бүхий төрөлжсөн шүүх болсон.

Бүгд Найрамдах Молдов улсын Нягтлан бодох бүртгэлийн шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар Нягтлан бодох бүртгэлийн шүүх нь төрийн санхүүгийн хяналт тавих байгууллага бөгөөд Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хуулийн дагуу үйл ажиллагаа явуулна. Тус шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагаа нь хараат бус байна.²⁴

Нягтлан бодох бүртгэлийн шүүхийн үйл ажиллагаанд дараах зарчим, хүрээг баримтална. Үүнд:

- Нийтийн санхүүгийн нөөц, эд хөрөнгийн удирдлагыг үр ашигтай, уян хатан, хууль ёсны олж авах
- Нийтийн санхүүгийн удирдлагын хүрээний хариуцлагатай, ил тод байдлын олон улсын стандартыг хүлээн зөвшөөрч дэмжих
- Нийтийн аудитын ажилтнуудыг батламжлах.

2.4. Беларусь улсын шүүхийн тогтолцоо



Шүүхийн тогтолцоо нь нутаг дэвсгэрийн болон төрөлжсөн гэсэн үндсэн зарчимд тулгуурлана.²⁵ Шүүх эрх мэдлийг Үндсэн хуулийн, ердийн, эрүүгийн, аж ахуйн болон бусад шүүх хэрэгжүүлнэ гэжээ.²⁶

Үндсэн хуулийн шүүх

Үндсэн хуулийн шүүх нь 12 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлнэ.²⁷ Үндсэн хуулийн шүүх нь дараах акт тус улсын Үндсэн хууль

²³Бүгд Найрамдах Молдов улсын Үндсэн хууль

https://www.constituteproject.org/constitution/Moldova_2006?lang=en

²⁴ Law of the Republic of Moldova On The Court Of Accounts No 312-XIII dated 08.12.94

http://www.ccrm.md/file/Acte_leg/en/law_court%20of%20accounts.doc.

²⁵ Беларусь улсын Үндсэн хуулийн 109 дүгээр зүйл

²⁶ Беларусь улсын Шүүхийн байгууламж, түүний эрх зүйн байдлын тухай хууль

²⁷ Беларусь улсын Үндсэн хуулийн 116 дугаар зүйл



болон соёрхон баталсан олон улсын эрх зүйн акт, хууль, захирамж, зарлигт нийцэж байгаа талаар дүгнэлт гаргана:

- Ерөнхийлөгч, Төлөөлөгчдийн танхим, Улсын зөвлөл, Дээд шүүх, аж ахуйн Дээд шүүх, Сайд нарын зөвлөлийн хүсэлтээр хууль, тогтоол, ерөнхийлөгчийн зарлиг
- Улс хоорондын байгууллагын акт, хууль биелүүлэх талаарх Ерөнхийлөгчийн зарлиг
- Сайд нарын зөвлөлийн тогтоол, Дээд шүүх, аж ахуйн Дээд шүүх, Ерөнхий прокурорын акт
- Төрийн бүх байгууллагын акт.

Хуульд заасан тохиолдолд Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгчийн саналын дагуу парламентын танхимууд Үндсэн хуулийг тогтмол болон бүдүүлгээр зөрчдөг баримт байгаа талаар дүгнэлт гаргаж болно.

Ердийн болон дагнасан шүүх

Ердийн болон аж ахуйн шүүхийн тогтолцоонд дагнасан коллегийг, хуульд заасан тохиолдолд насанд хүрээгүйчүүдийн, гэр бүлийн, захиргааны, газрын, татварын асуудлаар дагнасан шүүхийг байгуулж болно. Ердийн шүүхийн тогтолцоонд Дээд шүүх, мужийн шүүх, Минск хотын шүүх, дүүргийн шүүх орно.

Дээд шүүх: тус улсын ердийн шүүхүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хэргийг давж заалдах болон хяналтын журмаар, шинээр илэрсэн нөхцөл байдлаар, хуульд заасан тохиолдолд тодорхой хэргийг анхан шатаар хянан шийдвэрлэнэ. Мөн шүүхийн практикийг судлан нэгтгэх, шүүхийн статистикт дүн шинжилгээ хийх, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх явцад хууль тогтоомжийг хэрэглэх асуудлаар тайлбар гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Дээд шүүхийн тайлбарыг шүүх, хууль хэрэглэдэг байгууллага, албан тушаалтан заавал дагаж мөрдөнө.

Мужийн, Минск хотын шүүх: Хэргийг анхан, давж заалдах, хяналтын журмаар, мөн шинээр илэрсэн нөхцөл байдлаар хянан шийдвэрлэх бөгөөд дүүргийн /хотын/ шүүхүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийг нэг мөр хэрэглэх талаар туслалцаа үзүүлнэ.

Дүүргийн шүүх: шүүхийн дарга, шүүгч, захиргааны хэргийн шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шүүгчдээс бүрдэнэ. Дүүргийн шүүх нь хууль тогтоомжоор дээд шатны шүүхэд харьяалуулснаас бусад эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг, маргааныг анхан шатаар хянан шийдвэрлэнэ.

Аж ахуйн шүүх: Аж ахуйн Дээд шүүх, мужийн аж ахуйн шүүхүүд, хотын болон дүүргийн аж ахуйн шүүхүүд хамаарна. Аж ахуйн шүүх нь эдийн засгийн харилцааны хүрээнд иргэн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалуулсан эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлнэ. Аж ахуйн шүүхүүдийн нэгдмэл тогтолцоог аж ахуйн Дээд шүүх, мужийн аж ахуйн шүүхүүд, Минск хотын аж ахуйн шүүх болон дагнасан /дампуурлын, газрын, татварын зэрэг/ шүүхүүд бүрдүүлнэ.²⁸

²⁸ Беларусь улсын Аж ахуйн шүүхийн тухай хууль



2.5. Узбекистан улсын шүүхийн тогтолцоо



Тус улсын шүүхийн тогтолцоо нь Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, аж ахуйн Дээд шүүх, орон нутгийн, дүүргийн, хотын, аж ахуйн шүүхээс бүрдэнэ. Онцгой шүүх байгуулахыг хориглоно.


Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлнэ. Тус байгууллага 1992 оны Үндсэн хуулиар батлагдаж, 1995 онд байгуулагдаж, 1996 онд ажиллаж эхэлсэн. Тус шүүх нь парламентын баталсан хууль болон бусад акт, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон орон нутгийн захиргааны байгууллагын тогтоол, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг тодорхойлно; Үндсэн хууль бусад хуулийн хэм хэмжээг тайлбарлана; эрх хэмжээнд хамаарах бусад хэргийг хянан шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нийтлэгдмэгц хүчин төгөлдөр болно. Уг шийдвэр нь эцсийн бөгөөд давж заалдахгүй.

Улсын Дээд шүүх нь иргэний, эрүүгийн, захиргааны шүүн таслах хүрээн дэх шүүх эрх мэдлийн дээд байгууллага юм. Түүний баталсан акт нь эцсийн бөгөөд тус улсын нутаг дэвсгэрт заавал дагаж мөрдөнө.

Аж ахуйн Дээд шүүх болон аж ахуйн бусад шүүх эрх хэмжээнийхээ дагуу эдийн засгийн хүрээнд болон түүнийг удирдах явцад өмчийн янз бүрийн хэлбэрийн үйлдвэр, албан газар, байгууллага хооронд түүнчлэн аж ахуй эрхлэгчдийн хооронд үүссэн аж ахуйн маргааныг шийдвэрлэнэ.



2.6. Турк улсын шүүхийн тогтолцоо



Турк улсын шүүхийн тогтолцоо нь эрүү-иргэний хэргийн ердийн шүүх /адлие/, захиргааны шүүх /идарл/, тусгай шүүх /хусуш/-ээс бүрдэнэ. Зохион байгуулалт, бүтцийн шинжээр нь шүүхүүдийг хэд хэдэн бүлэг болгодог.

Үндсэн хуулийн шүүх

1961 онд Үндсэн хуулийн шүүх байгуулагджээ. Уг шүүх нь Үндсэн хуульд хууль, хуулийн хүчин чадалтай тогтоол, Үндэсний зөвлөлийн дүрэм нийцэж байгааг хэлбэр болон агуулга талаас нь хянана. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг зөвхөн хэлбэр талаас нь хянана. Тус шүүх нь дээд шүүхийн хувьд Ерөнхийлөгч, Сайд нарын зөвлөлийн гишүүн, Үндсэн хуулийн шүүх, Хяналтын дээд шүүх, Төрийн зөвлөл, Цэргийн хяналтын дээд шүүх, Цэргийн захиргааны дээд шүүхийн дарга, гишүүд, тэдгээрийн Ерөнхий прокурор, улсын Ерөнхий прокурорын орлогч, шүүгч, прокуроруудын дээд зөвлөл, Тооцооны шүүхийн дарга, гишүүдийн чиг үүрэгтэй холбоотой гэмт хэргийг хянан хэлэлцэнэ. Дээд шүүхэд прокурорын үүргийг улсын Ерөнхий прокурор, түүний орлогч гүйцэтгэнэ. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр эцсийнх бөгөөд давж заалдахгүй. Үндсэн хуулийн шүүх нь хууль болон хуулийн хүчин чадал бүхий тогтоолыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгохдоо хууль тогтоогчийн адил хэм хэмжээ тогтоох эрхгүй байна.²⁹

Дээд шатны шүүх

Дээд шатны шүүхэд Үндсэн хуулийн шүүх, Дээд давж заалдах шатны шүүх, Төрийн зөвлөл, Цэргийн дээд давж заалдах шатны шүүх, Цэргийн захиргааны дээд шүүх, Хууль зүйн зөрчилдөөний шүүх орно. Эдгээр шүүхийн эрх хэмжээ, байгуулах журмыг Үндсэн хуулиар ерөнхийд нь зохицуулсан.

Анхан шатны шүүх

²⁹ Турк улсын Үндсэн хуулийн 153 дугаар зүйл



Анхан шатны шүүхэд мужийн төв болон томоохон хотуудад байдаг үндсэн шүүхүүд орно. Эдгээр нь хэд хэдэн төрөлд хуваагддаг. Үүнд: эрүүгийн онц хүнд гэмт хэргийг шийдвэрлэх үндсэн шүүх, эрүүгийн хэргийн үндсэн шүүх, иргэний болон аж ахуйн хэргийн үндсэн шүүх байна.

Эрүүгийн хэргийн шүүхэд Улсын аюулгүй байдлын шүүхүүд онцгой байр суурьтай. Тэдгээр нь 1980-аад оноос улс төрийн хууль зүйн байнгын ажиллагаатай байгууллага болжээ. Эдгээр шүүх нь төр, түүний үндэстэн болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ардчилсан чөлөөт байгуулалт буюу бүгд найрамдах улсад халдсан гэмт хэрэг, мөн улсын дотоод, гадаад аюулгүй байдалтай холбоотой гэмт хэргийг хянан хэлэлцэнэ.³⁰ Улсын аюулгүй байдлын шүүх нь Засгийн газраас дөрвөн жилийн хугацаагаар томилогддог дарга, хоёр үндсэн, хоёр туслах гишүүнээс бүрдэнэ. Тус шүүхийн шийдвэртэй холбогдсон гомдлоо Хяналтын шатны дээд шүүхэд гаргана.

Захиргааны хэргийн шүүх

Туркэд захиргааны шүүхийн байгууллагын бие даасан тогтолцоо уламжлагдсан байна. Орон нутагт захиргааны шүүхийн үүргийг захиргааны байгууллагын албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хянан хэлэлцдэг тойрог, мужийн захиргааны зөвлөл ба татвар-нэхэмжлэлийн комисс гүйцэтгэнэ. Хуульд заасан зарим хэргийг анхан болон эцсийн шатны журмаар шийдвэрлэнэ.

Цэргийн хэргийн шүүх

Цэргийн шүүхийн байгууллага нь тусгай шүүхэд хамаарах бөгөөд цэргийн ба цэргийн сахилгын гэж хуваагдана. Эдгээр шүүх нь цэргийн албан хаагчдын үйлдсэн цэргийн гэмт хэрэг; цэргийн бус этгээдийн үйлдсэн цэргийн гэмт хэрэг; хуульд заасан үүргээ гүйцэтгэж буй цэргийн албан хаагчдын эсрэг үйлдсэн гэмт хэрэг; хуулиар тогтоосон цэргийн бүсэд үйлдэгдсэн гэмт хэргийг тус тус хянан шийдвэрлэнэ. Цэргийн захиргааны дээд шүүх нь цэргийн албанд хамааралтай, эсхүл цэргийн албан тушаалтанд халдсан захиргааны акт болон үйлдлээс үүдсэн маргааны талаарх шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх анхан болон эцсийн шатны шүүх байна.

Хэргийн харьяаллын маргааны шүүх

Хэргийн харьяаллын маргааны шүүх нь шүүхийн харьяалал болон шүүхүүдийн шийдвэрийн талаар шүүхүүд хооронд, захиргааны болон цэргийн шүүхүүд хооронд гарсан маргааныг шийдвэрлэнэ.

Ердийн шүүх

Ердийн шүүхэд дээд шүүх, давж заалдах шатны тойргийн шүүх, анхан шатны шүүх буюу иргэний эрх зүйн шүүх, эрүүгийн эрх зүйн шүүх багтана.³¹

Дээд шүүх нь танхим, зөвлөл, зөвлөгөөний хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг. Мөн Ерөнхий прокурор тус шүүхийн бүтцэд байдаг.

Танхим нь иргэний эрх зүйн 23 танхим, эрүүгийн эрх зүйн 15 танхимаас бүрдэнэ. Танхим нь хуульд зааснаар анхан шатны болон тойргийн шүүхийн шийдвэрт давж

³⁰ Турк улсын Үндсэн хуулийн 143 дугаар зүйл

³¹ Turkish Judicial System Bodies, Duties And Officials By İsmail Aksel Judge
<http://www.justice.gov.tr/judicialsystem.pdf>



заалдах шатны хяналт тавина. Танхим бүр 1 тэргүүн, 9 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээр нь 5 гишүүнтэй хоёр багт хуваагдан ажилладаг.

Зөвлөгөөн нь иргэний эрх зүйн танхимын зөвлөгөөн болон эрүүгийн эрх зүйн танхимын зөвлөгөөн бүрдэх бөгөөд түүний үндсэн чиг үүрэг нь Ерөнхий прокурор эсэргүүцэл гаргасан тохиолдолд танхимын шийдвэрийг хянаж, эцэслэн баталгаажуулдаг.

Давж заалдах шатны тойргийн шүүх нь бүс нутгийн шүүх бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гарснаар тухайн шийдвэрийг хянадаг. Ийм шүүх нь Туркт 15 өөр нутаг дэвсгэрийг хамран байгуулагдсан. Давж заалдах шатны тойргийн шүүх нь иргэний хэргийн 3 танхим, эрүүгийн хэргийн 2 танхимаас бүрдэнэ.

Анхан шатны ердийн шүүх нь иргэний эрх зүйн шүүх болон эрүүгийн эрх зүйн шүүх гэж хоёр хуваагддаг. Эрүүгийн эрх зүйн шүүх нь Эрүүгийн хуулийн тодорхой төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх, эрүүгийн хэргийн шүүх гэсэн үндсэн ангилалтай. Эрүүгийн хуулийн тодорхой төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх нь терроризм, насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг зэрэг хуульд тусгайлан заасан хэргийг хянан шийдвэрлэдэг. Харин эрүүгийн хэргийн шүүх нь өмчийн эсрэг гэмт хэрэг гэх мэт бусад төрлийн хэргийг шүүн шийдвэрлэнэ.

2.7. Эстони улсын шүүхийн тогтолцоо



Бүгд Найрамдах Эстони Улсын Үндсэн хуулийн 148 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн үндсэн тогтолцоо нь Дээд шүүх /хяналтын шатны шүүх/, тойргийн шүүх /давж заалдах шатны шүүх/, мужийн шүүх, захиргааны хэргийн шүүх³² /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.

Дээд шүүх бол Эстони Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үздэгээс гадна давхар Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий шүүх болно.³³ /Эстонд хуучин зөвлөлтийн бусад улсаа ялгаатай нь Үндсэн хуулийн шүүх буюу үндсэн хуулийн хяналтын бие даасан байгууллага байхгүй./ Ийнхүү Дээд шүүх нь хяналтын шатны шүүхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна давхар Үндсэн хуулийн шүүхийн үйл

³² Захиргааны хэргийн шүүх нь Эстон Улсын цорын ганц дагнасан шүүх юм.

³³ Эстон Улсын Үндсэн хуулийн 149 дүгээр зүйл




ажиллагааг хэрэгжүүлдэг онцлогтой. Одоогийн байдлаар Эстони Улсын шүүх нь 242 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.³⁴

Орон нутгийн болон нийслэлийн шүүх дээр шүүхийн шийдвэр нь нэг шүүгч болон хоёр иргэдийн төлөөлөгчийн олонхийн саналаар гардаг. Ийм шүүх нь анхан шатны шүүх бөгөөд Эстони улсад нийт 20 шүүх бий. Үүнд нийслэлийн 2 шүүх, орон нутгийн 14 шүүх, захиргааны хэргийн 4 шүүх хамаарна. Дээд шүүх нь 17 шүүгчтэй байдаг.³⁵

Эстони улсын арбитрын шүүх нь өмнө нь шүүх дээр шийдвэрлэгдээгүй иргэний хэргийг хүлээн авч шийдвэрлэдэг. Арбитрын анхан шатны шүүх нь дараах хэргийг шийдвэрлэнэ. Үүнд:³⁶

- Хөдөлмөрийн маргаан
- Түрээсийн маргаан
- Хэрэглэгчийн гомдолтой холбоотой маргаан
- Даатгалын зөрчил
- Нийтийн худалдан авах ажиллагаатай холбоотой маргаан /тендерийн маргаан/
- Арилжааны болон үйлдвэрийн маргаан.

2.8. Казахстан улсын шүүхийн тогтолцоо



Казахстаны шүүхийн тогтолцоог Дээд шүүх, мужийн шүүхүүд болон орон нутгийн шүүхүүд бүрдүүлдэг.³⁷ Дээд шүүх, мужийн болон Алмата хотын шүүх нь эрүүгийн, иргэний, аж ахуйн хэргийг хянан шийдвэрлэнэ.

Дүүргийн, хотын болон цэргийн шүүхүүд нь тэдгээрт харьяалагдах иргэний, эрүүгийг хэргийг хянан хэлэлцэнэ. Казахстаны дээд шүүх нь эрүү, иргэний болон ердийн шүүхэд харьяалагдах бусад хэргийн шүүхийн дээд шатны байгууллага бөгөөд хуульд заасан хэлбэрээр доод шатны шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шүүхийн практикийн асуудлаар тайлбар гаргана.

Үндсэн хуулийн шүүх нь 1993 оны Үндсэн хуулийн дагуу байгуулагдаж, дараа нь 1995 оны Үндсэн хуулийн дагуу татан буугдсан байна. Харин Францын загвар бүхий Үндсэн хуулийн зөвлөл байгуулагджээ. Үндсэн хуулийн зөвлөл нь тухайн эрх зүйн

³⁴ Supreme Court website: <http://www.riigikohus.ee/?lang=en>

³⁵ Estonia - Judicial system <http://www.nationsencyclopedia.com/Europe/Estonia-JUDICIAL-SYSTEM.html>

³⁶ A Guide to Estonian Courts. 2015 <http://www.lawyersestonia.com/a-guide-to-estonian-courts>

³⁷ Ч.Энхбаатар, С.Зүлфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. Улаанбаатар. 2014. 371 дэх тал



актыг Үндсэн хуульд нийцэхгүй байгаа тухай шүүхээс хүсэлт гаргасан тохиолдолд л Үндсэн хуулийн дараагийн хяналтыг хэрэгжүүлнэ. Тус зөвлөлийн шийдвэрт Ерөнхийлөгч бүхэлд нь буюу хэсэгчлэн хориг тавьж болно. Энэ хоригийг Үндсэн хуулийн зөвлөлийн нийт гишүүний 2/3-ын саналаар шийдвэрлэнэ.³⁸

3. ДҮГНЭЛТ

Дээр судалсан улс орнуудад Үндсэн хуулийн шүүх болон Дээд шүүхийн чиг үүрэг, шийдвэрлэх маргааны төрөл нь Монгол Улсын зохицуулалттай адил байна.

Харин төрөлжсөн буюу дагнасан шүүхтэй улсуудад ийм шүүх нь цэргийн шүүх, арбитрын шүүх, эвлэрлийн шүүх, далайн хэргийн шүүх, тооцооны шүүх, аж ахуйн шүүх болон захиргааны хэргийн шүүх хамаарч байна. Тодруулбал, хэрэг, маргааны төрлөөр төрөлжиж дагнасан шүүхүүдийг тухайн онцлог шаардлагаас хамаарч байгуулдаг байна.

Зарим улсад ийм дагнасан шүүхийн давж заалдах шатны шүүх байгаа бөгөөд аль ч дагнасан шүүх нь Дээд шүүхийн хяналтад байхаар зохицуулжээ.

Иргэн, эрүүгийн хэргийн хувьд дагнасан шүүхэд хамаарахгүй ердийн буюу нийтлэг хэргийн шүүх байхаар зохицуулсан нь улс орнуудад нийтлэг байна.

Шүүхийн тооны хувьд улс орнууд харилцан адилгүй хэдий ч засаг захиргааны нэгж болон хүн амын тоотой харилцан уялдсан шинжтэй байна.

Эцэст нь дурдахад, улс орнуудын шүүхийн тогтолцоо нь иргэдийн шударга, мэргэжлийн шүүхээр үйлчлүүлэх эрхийг хангах, шүүх эрх мэдлийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд чиглэж байна.



³⁸ Ред. Ж.Амарсанаа, Н.Тунгалаг. Дэлхийн улсуудын шүүхийн тогтолцоо. Улаанбаатар. 2005. 21, 23 дахь тал